

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

**2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр, Мягмар гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-8

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 9-31

---

**1.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/** 10-29

**2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/** 29-30

**3.Байнгын хорооны даргыг сонгох тухай** 30-31

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны  
4 дүгээр сарын 28-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 38 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: П.Батчимэг, Г.Ганбаатар, С.Ганбаатар, Ц.Мөнхбат, Р.Сэддорж;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, О.Амгаланбаатар, Л.Мөнхбаясгалан, Т.Мөнхсайхан, Ц.Туваан.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг үг хэлэв.

**Нэг.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Х.Мөнхзул, Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн дарга Б.Алтанзул, судлаач И.Бямбахүү, хуульч, судлаач М.Энхмэнд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, П.Хулан, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга танилцуулав.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, М.Ганхүлэг, М.Мандхай, Б.Бейсен нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн дарга Б.Алтанзул нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 2, 4, 5, 6, 7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Б.Бейсен:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.9.Төслийг байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, цар хүрээ, төсөл хэрэгжих газар нутгийн байршил, хүчин чадлыг харгалзан дараах байдлаар ангилна.Үүнд:

7.9.1.зэрэглэл I буюу их эрсдэлтэй төсөлд байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх сөрөг болон хуримтлагдах нөлөөлөл нь төслийн нөлөөллийн бүсийн хэмжээгээр хязгаарлагдахгүй, байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулахад нэмэлт арга хэмжээ шаардлагатай, газар чөлөөлөлтийн хамрах хүрээ ихтэй үйл ажиллагааг;

7.9.2.зэрэглэл II буюу дунд эрсдэлтэй төсөлд байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь төслийн нөлөөллийн бүсийн хэмжээгээр хязгаарлагдах боломжтой, байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулахад нөхцөл, болзолтой арга хэмжээ шаардлагатай, газар чөлөөлөлтийн хамрах хүрээ хязгаарлагдмал үйл ажиллагааг;

7.9.3.зэрэглэл III буюу бага эрсдэлтэй төсөлд байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл хязгаарлагдмал, эсхүл эрсдэлгүй үйл ажиллагааг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, С.Замира нар хуралдааны тэмдэглэлд санал хураалтад дэмжсэнээр тэмдэглүүлэх санал гаргаж, 72.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.13.Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны ерөнхий үнэлгээнд санал авах хүсэлтийг төслийн товч танилцуулга, газрын эрхтэй холбоотой баримт бичгийн хамт тухайн сум, дүүргийн Засаг даргад гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 8  
Бүгд: 18  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, С.Замира нар хуралдааны тэмдэглэлд санал хураалтад дэмжсэнээр тэмдэглүүлэх санал гаргаж, 66.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.14 дэх хэсгийн “ажлын 10 хоногт” гэснийг “ажлын 15 хоногт” гэж, “хариу өгсөнд” гэснийг “зөвшөөрсөнд” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18  
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нар хуралдааны тэмдэглэлд санал хураалтад дэмжсэнээр тэмдэглүүлэх санал гаргаж, 66.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 18.7-д заасан “Иргэн тухайн төслийн үйл ажиллагаатай холбогдуулан газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаарх мэдээлэл авах, танилцах хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгчид гаргаж болно.” гэснийг “Иргэн тухайн төслийн үйл ажиллагаатай холбогдуулан газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаар мэдээлэл авах, танилцах хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгч төрийн байгууллага, албан тушаалтанд гаргаж болох бөгөөд төслийн нөлөөлөлд өртөх иргэдийн олонхын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр байгаль орчны нөлөөллийн үнэлгээг эергээр дүгнэхийг хориглоно.” гэж өөрчлөн найруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, М.Ганхүлэг нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

гишүүн Б.Уянга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, мөн яамны Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн дарга Б.Алтанзул нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 14  
Бүгд: 18  
22.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, 1 дүгээр зүйлийн хуулийн төслийн 7.14-д нэмэлтээр орж буй сум, дүүргийн Засаг дарга нь төсөл хэрэгжүүлэгчээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, ажлын 10 хоногт багтаан хариу өгөх бөгөөд энэ хугацаанд шийдвэрлээгүй тохиолдолд хариу өгсөнд тооцно гэсэн заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 14  
Бүгд: 18  
22.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “3.1.4 дэх заалтын “үнэлгээ гэж” гэсний дараа “зэрэглэл I, зэрэглэл II” гэж,” гэснийг, төслийн 4 дүгээр зүйлийн “3 дугаар зүйлийн 3.1.4 дэх хэсгийн “байгаль орчны” гэснийг “байгаль орчин, нийгмийн” гэж,” гэснийг болон төслийн 5 дугаар зүйлийг хасаж, 3.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж төслийн 3 дугаар зүйлд нэмэх:

“3.1.4.“байгаль орчны төлөв байдлын үнэлгээ” гэж зэрэглэл I, зэрэглэл II төслийн техник, эдийн засгийн төлөвлөлтийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн төлөв байдлыг судлан тогтоож цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлохыг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 10  
Бүгд: 18  
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Замирагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Б.Бейсен:** Улсын Их Хурлын гишүүн С.Замирагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18  
61.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Б.Бейсен:** 6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “3.1.4 дэх заалтын “үнэлгээ гэж” гэсний дараа “зэрэглэл I, зэрэглэл II” гэж,” гэснийг, төслийн 4 дүгээр зүйлийн “3 дугаар зүйлийн 3.1.4 дэх хэсгийн “байгаль орчны” гэснийг “байгаль орчин, нийгмийн” гэж,” гэснийг болон төслийн 5 дугаар зүйлийг хасаж, 3.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж төслийн 3 дугаар зүйлд нэмэх:

“3.1.4.“байгаль орчны төлөв байдлын үнэлгээ” гэж зэрэглэл I, зэрэглэл II төслийн техник, эдийн засгийн төлөвлөлтийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн төлөв байдлыг судлан тогтоож цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлохыг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.6.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ерөнхий шинжээч, шинжээчийн эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага олгох бөгөөд тэдгээр нь дараах шаардлагыг хангасан байна:

7.6.1.ерөнхий шинжээч нь Төрийн албаны тухай хуулийн 23.2.2-т заасан шаардлагыг хангасан, байгаль орчны чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байх;

7.6.2.шинжээч нь Төрийн албаны тухай хуулийн 18.1.4-т заасан шаардлагыг хангасан, байгаль орчны чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 6  
Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.4.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр батлагдсан менежментийн төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах, хянах, тайлагнах журам, аргачлалыг

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 6  
Бүгд: 18  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийн "хамтран" гэсний дараа "төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа," гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 6  
Бүгд: 18  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу 14.1.2 дахь заалтын "орон нутгийн захиргаа" гэснийг "нутаг дэвсгэрийн захиргаа" гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 6  
Бүгд: 18  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, “Хуулийн төслийн 10.5-д байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланг төслийг хэрэгжүүлэгч үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулна.” гэснийг “байгаль орчинд нөлөөллийн үнэлгээний тайланг төслийг хэрэгжүүлэгч үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулах бөгөөд төслийн улмаас иргэдэд учирсан хохирол, зардал, амьжиргааны алдагдал, усны хүртээмж, байгаль орчин, нийгэм, соёлын орчинд үзүүлсэн үр дагавар, нөлөөллийг хамааруулан иж бүрнээр үнэлж бүрэн нөхөн төлнө.” гэж өөрчлөн найруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 13  
Бүгд: 18  
27.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

12.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Хуулийн төслийн 10.4-д “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 10.5-д заасан танилцуулгаас гарсан саналын нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан эсэх болон үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээч

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.” гэснийг “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 10.5-д заасан танилцуулгаас гарсан саналыг нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан эсэх болон үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээч мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэх бөгөөд хэрэв байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тухайн төсөл нь усны нөөц, амьжиргааны тогтвортой байдалд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх нь тогтоогдсон тохиолдолд төслийг хэрэгжүүлэхийг хориглоно.” гэж өөрчлөн найруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2  
Татгалзсан: 16  
Бүгд: 18  
11.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн хуулийг дагаж мөрдөх хугацааг “2026 оны 8 дугаар сарын 01” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 5  
Бүгд: 18  
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томьёог жигдлэх, зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх, бүтэц найруулга, хууль зүйн техникийн засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 5  
Бүгд: 18  
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 13 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, П.Хулан, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Бейсен тогтоолын төслийн талаар танилцуулав.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг үг хэлэв.

**Б.Бейсен:** “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 3

Бүгд: 18

83.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, ажлын хэсгийн гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай, Б.Бейсен, Ж.Чинбүрэн, М.Ганхүлэг, А.Ундраа нар ажиллахаар тогтов.

*Уг асуудлыг 13 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.*

### **Гурав.Байнгын хорооны даргыг сонгох тухай**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга У.Отгонбаяр Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлсэн талаар танилцуулав.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Ч.Лодойсамбуу ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, Байнгын хорооны дарга Б.Бейсен уг асуудлаар ажлын 5 өдрийн завсарлага өгөв./13:51/

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 13 минут үргэлжилж, 29 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 62.1 хувийн ирцтэйгээр 13 цаг 51 минутад өндөрлөв.*

#### **Тэмдэглэлтэй танилцсан:**

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХ УЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

#### **Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
12 цаг 38 минут.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Б.Бейсен:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 55.2 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны нэрсийг гишүүн, сонгосон тойрог бүрээр танилцуулъя.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Буланы Бейсен гишүүн ирсэн байна. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн ирсэн байна. Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн байна. Ухнаагийн Отгонбаяр гишүүн ирсэн байна. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн байна. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Хассуурийн Ганхуяг гишүүн ирсэн байна. Сонгобайн Замира гишүүн ирсэн байна. Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна. Агваанлуvsангийн Ундраа гишүүн ирсэн байна. Далайн Батбаяр гишүүн ирсэн байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна. Сүрэнжавын Лүндэг гишүүн ирсэн байна. Салдангийн Одонтуяа гишүүн ирсэн байна. Болдын Уянга гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал танилцуулъя.

Хэлэлцэх асуудал нэг, Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газрын 2025 оны 5 сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

Хоёр дахь асуудал, Байнгын хорооны тогтоолын төсөл, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай.

Гуравд нь “Бусад” гээд асуудал орж байна.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу?

Ганхүлэг гишүүн.

**М.Ганхүлэг:** Гишүүдийнхээ ирц, оролцоог хараад “Бусад” асуудлаа эхлээд ярьчихмаар юм уу? Тэгээд санал хураалт юмнууд байвал.

**Б.Бейсен:** Юу гэсэн гэнэ ээ?

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**М.Ганхүлэг:** Хэлэлцэх асуудлынхаа дарааллаар бусад асуудлаа түрүүлж яриад ирц, оролцоо их байгаа дээр ярьчихмаар юм уу. Тэгээд үргэлжлүүлээд явчихвал яасан юм гэсэн.

**Б.Бейсен:** Ганхүлэг гишүүн санал гаргасан байна. Хэлэлцэх асуудлын эхэнд оруулъя гээд. Нэгэнт одоо гишүүд ирц бүрдэж байгаа юм чинь гурав дахь асуудал болчих байх гэж бодож байна л даа. Хуралдаануудаараа сүүлийн хуралдаан тэгээд удирдаад явуулчихъя. Хүрчих байх аа. Хуралдааны дарааллаар явчихъя. Хэлэлцэх асуудалд оръё.

### **Байгаль орчинд нөлөөлөх байдал үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулъя.**

Ажлын хэсгийг танилцуулъя. Сандаг-Очир Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Ш.Батбаяр Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ц.Уранчимэг Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Х.Мөнхзул Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга, Б.Алтанзул Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн дарга, И.Бямбахүү судлаач, М.Энхмэнд хуульч, судлаач.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг Байнгын хорооноос байгуулагдан ажилласан. Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Уянгаа танилцуулна.

**Б.Уянга:** Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх хэсгийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн, Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр тус Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны болгон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 2025 оны 19 дүгээр тоот тогтоолоор байгуулсан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай, Б.Бат-Эрдэнэ, Г.Ганбаатар, С.Замира, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, С.Одонтуяа нарын гишүүд ажиллалаа.

Ажлын хэсэг энэ хугацаанд нийт 5 удаа хуралдаж, түүнчлэн хуулийн төслийн талаарх хэлэлцүүлгийг Дундговь, Говьсүмбэр аймагт зохион байгуулж, холбогдох саналыг тусган дараах танилцуулгыг Байнгын хороонд танилцуулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

Төслийг байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, цар хүрээ, төсөл хэрэгжих газар нутгийн байршил, хүчин чадлыг харгалзан 3 зэрэглэлд ангилж, байгаль орчин,

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх нөлөөллийнх нь хэмжээг тус бүр тодорхойлох;

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ерөнхий шинжээчийн эрхийг төрийн захиргааны төв байгууллага олгох;

Ерөнхий шинжээч нь Төрийн албаны тухай хуульд заасан шаардлагыг хангасан, байгаль орчны чиглэлээр ажилласан жил, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгч мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байх шаардлагыг тусгах;

Төсөл хэрэгжүүлэгчээс сум, дүүргийн Засаг даргад ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх хугацаанд өөрчлөлт оруулах;

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн захиргаа төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулах;

Хуулийг 2026 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгаж, төслийн нэр, томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх, бүтэц найруулга, хууль зүйн техникийн засварыг хийлээ.

Эдгээр өөрчлөлтүүдтэй холбогдуулан төслийн талаар гаргах зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн болно.

Ажлын хэсгийн бэлтгэсэн танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Б.Бейсен:** Уянгаа гишүүнд баярлалаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ гэж заасны дагуу хэлэлцье. Гишүүд та бүхэн тухайн хуультай холбогдуулан асуулт асууж болно.

Хуулийн төсөл 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрс өгнө үү?

Батбаяр гишүүнээр тасалъя. Далайн Батбаяр гишүүн асуулт асууя.

**Д.Батбаяр:** Байнгын хорооны болон ажлын хэсгийнхний энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд энэ ажлын хэсгийн саналын томъёололтой холбоотойгоор асуух юм уу, эсвэл бүүр хуультай холбоотойгоор асуух юм уу? Зөвхөн 1 дүгээр зүйлтэй холбоотойгоор асуух болж таарч тээ? Тэгээд ер нь энэ байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ бол 5 төрөл байгаад байгаа тээ? Стратегийн тэгээд тэр хуримтлагдах мэдээллийн гээд. Тэгээд энэ 7.9 дээр төслийг байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, цар хүрээ, төсөл хэрэгжих газар нутгийн байршил, хүчин чадлыг харгалзан дараах байдлаараа ангилна гэж байна л даа. Тэгээд энэ ангиллыг энэ үнэлгээнүүдийг хийгдсэний дараа ингэж яг бүгдийг нь ялгаж эргэж гаргахаар болж таарч байна уу тээ? Ажлын хэсгийнхнээс тийм асуулт байгаад байна.

Ер нь бол энэ шинээр орж ирж байгаа хуулийн төсөл маань ерөөсөө орон нутагт явагдаж байгаа аливаа ажлыг илүү хурдасгах, илүү хяналт тавиад дүн шинжилгээ хийсний тэр ард дээр нь илүү хурдан бүтээдэг тал руугаа л чиглэж явах ийм бодлогыг барих ёстой гэж би хараад байгаа юм.

Тэгэхээр энэ 7.9 дээр орж ирж байгаа санал дээр нь ангилал хийнэ ээ гэсэн байгаад байна. Тэгэхээр ангилал хийх дараалал маань чухам яаж явах вэ гэж ийм асуулт байгаад байна.

**Б.Бейсен:** Хэн хариулах вэ? 6 номер хариульъя Төрийн нарийн бичгийн дарга.

**Ш.Батбаяр:** Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Төрийн нарийн бичгийн дарга Батбаяр байна. Батбаяр гишүүний хариулт асуултад хариульъя. Энэ ангилал, зэрэглэлийг бол 3 зэрэглэлээр хуваасан байгаа. Энийгээ их эрсдэлтэй буюу төсөлд нь бол байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх сөрөг болон хуримтлагдах нөлөөлөл нь төслийн нөлөөллийн бүсийн хэмжээгээр хязгаарлагдахгүй гэж байгаа. Энэ нь нөгөө гол, ус болон агаараар дамжин байгаль, экологи болон нийгэмд хохирол учруулах үзүүлэлт нь бол өндөр гэж тооцон үзүүлэлтийг хувааж байгаа.

Хоёр дахь зэрэглэлд нь бол байгаль орчны нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулахад нөхцөл болзолтой арга хэмжээг шаардлагатай газар чөлөөлөлтийн хамрах хүрээ хязгаарлагдмал үйл ажиллагааг оруулж байгаа.

Гурав дахь нь бол бага эрсдэлтэй төслүүдийг оруулж байгаа юм аа. Тэгээд энийг бол Засгийн газрын түвшинд журмаар зохицуулахаар байгаа.

**Б.Бейсен:** Хэдэн номер байна? 5 номер Уранчимэг дарга хариульъя.

**Ц.Уранчимэг:** Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газрын дарга Уранчимэг. Саяын гишүүний асуултад нэмэлтээр хариульъя. Тэгэхээр яг процессын хувьд асууж байна. Яг 1,2, 3 дугаар зэрэглэлд хуваарилж байгаа нь одоо яг төслүүд нь тодорхой хэмжээнд яг тухайн төслийн цар хүрээнээс шалтгаалаад ангиллаараа яг процессыг хялбаршуулж байгаа. Энэ хялбаршуулж байгаа харилцааг бол Засгийн газрын тогтоолоор батлаад яг одоо байгаа байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ болон нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллагын эрхтэй байгууллага хийдэг.

Тэгэхээр мэргэжлийн байгууллагын эрхтэй байгууллага нь яг энэ 1, 2, 3 дугаар зэрэглэлд яг нөлөөллөөсөө шалтгаалаад аль зэрэглэлийг сонгох вэ гэдгийг E-business-ээр оруулахдаа тэр рүү яг зэрэглэлд нийцсэн шалгуурыг хангаж байгаа зэрэглэлд тооцоод нөлөөллийнхөө үнэлгээг мэргэжлийн байгууллага хийгээд эхнээсээ явах процесс.

**Б.Бейсен:** Уянга гишүүн нэмж хариульъя.

**Б.Уянга:** Батбаяр гишүүний асуултад нэмэлтээр өгөхөд байгаль орчны үнэлгээ хийлгэдэг төслүүд бол маш олон байгаа. Ер нь бол газар дээр талбай

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

эзлээд байгаль орчинд нөлөөлөхүйц үйл ажиллагаа явуулах гэж байгаа төсөл болгон үнэлгээ хийлгэдэг. Та бас сайн мэдэж байгаа байх. Зэрэглэл 1, зэрэглэл 2, зэрэглэл 3-д ямар төслүүд орох вэ гэдэг дээр Хууль тогтоомжийн тухай хуулиараа энэ хуулийн төсөл засгаас өргөн баригдахдаа журам нь засгаар батлагдах журмын төсөл нь бол боловсруулагдсан орж ирсэн.

Тэгээд тэр дээр дурдагдсанаар жишээ нь зэрэглэл нэгд нь буюу байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл нь өндөр байх магадлалтай гэсэн төслүүдэд бүх төрлийн ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа, газрын тосны хайгуул, олборлолт, ер нь ашигт малтмал, металл боловсруулах үйлдвэр, хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэл зэрэглэл 1-тэй орсон байгаагаар төсөл бэлтгэгдсэн байна лээ.

Зэрэглэл 2-т болох болохлоор бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт ороод хөнгөн бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагаа, аялал жуулчлал, амралтын газар.../минут дуусав./

**Б.Бейсен:** Уянга гишүүн гүйцээж хариулъя.

**Б.Уянга:** Рашаан, сувиллын газар, худалдаа үйлчилгээний төв, зөөврийн болон гүний хутагтай авто угаалга, эрдэм шинжилгээний лаборатори, зам, тээвэр, хөдөө аж ахуйн химийн бордооны үйлдвэрүүд, хими цэвэрлэгээ, үйлчилгээний газар гэх зэрэг олон төслүүдээ болохоор зэрэглэл 2 буюу дунд хэмжээний нөлөөлөлтэй.

Зэрэглэл 3-д автомашины зогсоол, төвийн шугамд холбогдсон үйлчилгээний төв, авто угаалга, үсчин гоо сайхан, хэвлэл, алт, мөнгөний дархан, гар урлалын салбар гээд ингээд яг энэ байгаль орчинд үзүүлэх нөлөөллөөр нь ийм 3 зэрэглэлд хуваагдсан байсан. Журмын төсөл бол танилцуулагдсан. Засгийн газраар батлагдаад явахаар байгаа.

**Б.Бейсен:** Ганхүлэг гишүүн асуулт асууя.

**М.Ганхүлэг:** Томоохон төслүүдээ 1, 2, 3 буюу их, дунд, эрсдэлтэй гэсэн ийм зэрэглэлд хуваагаад ингээд явах юм байна. Илүү нарийвчилж байгаа нь бас зөв байна. Тэгэхдээ ямар үндэслэлээр аль нь зэрэглэлд аль аль төслүүдийг оруулах вэ гэдгийг хэн шийдэх вэ гэдгээ илүү бас тодорхойлох хэрэгтэй болох байх. Эрхийг журам гээд Засгийн газар бас авчих юм байна.

Тэгэхээр тодорхой өндөр эрсдэлтэй төслүүдийг Засгийн газрын тухайн цаг үеийн бас ач холбогдлоор нь хараад зэрэглэл бууруулаад явчихыг үгүйсгэхгүй ийм байдал руу бас орж магадгүй байна. Тэгэхээр энэ дээр ямар хамгаалалтыг хийх вэ, уул уурхайн болон томоохон байгаль орчинд бас сөрөг нөлөөтэй байж болох ийм төслүүдийг яаж маргашгүйгээр бид нар энэ зэрэглэлүүдтэй хувааж ангилах вэ гэдэг эхний асуулт байгаа. Хэн энийг шийдээд явж байгаагаа яаж шийд мэдэх вэ?

Хоёр дахь нь зэрэглэл тус бүр дээр төрийн оролцоо ямар байх юм бэ? Өндөр эрсдэлтэй болоод эхлэхээр төрийн оролцоо ямар болох юм? Тэр өндөр эрсдэл нэмэгдэх тусам бас иргэдийн оролцоог багийн нийтийн хурал, сумын, аймгийн удирдлагууд иргэдийн оролцоог нь зэрэглэл тус бүр дээр яаж харгалзаж

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

саналыг нь оруулж баталгаажуулж явах вэ? Тэгээд энэнтэй холбогдолтой тийм зохицуулалтыг яаж шийдэх вэ гэсэн 2 дахь асуулт.

**Б.Бейсен:** Хэн хариулах вэ? Уранчимэг дарга хариулъя 5 номер.

**Ц.Уранчимэг:** Саяын гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр яг зэрэглэл 1, 2, 3-ыг бол Засгийн газрын тогтоолоор батална гэж байгаа. Тэгэхээр өнөөдөр яг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дүгнэлт, ерөнхий дүгнэлтээ E-business-ээр оруулдаг. E-business-ээр оруулахад яг энэ зэрэглэлийн тэр шалгуур үзүүлэлтүүдийг оруулаад аль зэрэглэлд оруулж байгаа вэ гэдэг шалгуур үзүүлэлтүүдийг нь E-business-ийн систем дээрээ оруулаад өгөхөөр яг тэр шалгуур үзүүлэлт нийцсэн нь жишээлбэл саяын манай ажлын хэсгийн даргын хэлдгээр уул уурхайн төсөл, газрын тос, хүнд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын агуулга, цар хүрээ, хамрах нөлөөллийн бүсийн цар хүрээ хамрах гол асуудлуудаа шалгуур үзүүлэлтийг харгалзаж үзээд яг нөгөө зөвшөөрлөө мэргэжлийн байгууллагаар хийлгэж байгаа учраас мэргэжлийн байгууллага, төсөл хэрэгжүүлэгч 2 энэ сонголтоо хийгээд явах зохицуулалттайгаар E-business дээр энэ системийг яг хөгжүүлж өгнө.

Хоёр дахь асуулт бол аягүй чухал. Яг өнөөдөр бол яг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулиараа ИТХ-ын санал, дүгнэлтийг үндэслэж оруулж ирнэ гэхээр энэ дээр маш олон асуудал, чирэгдэл, нөгөө талдаа яг нөгөө иргэдийн саналыг тусгаагүйгээр зөвхөн төрийн захиргааны байгууллагын саналыг аваад шууд мэргэжлийн байгууллагын санал оруулж ирдэг байсан бол өнөөдрийн яг хуулиараа хуульчилж өгч байгаа хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр бол яг тухайн нөлөө хуулийн бүсэд үүсэж байгаа иргэдийн саналыг 100 хувь авч санал танилцуулгыг бэлтгэж оруулж ирнэ ээ гэдэг ийм нэмэлт, өөрчлөлт зарчмын санал орж байгаа.

**Б.Бейсен:** Уянга гишүүн хариулъя.

**Б.Уянга:** Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Төрийн оролцоо талд нь хариулъя. Түрүүний зэрэглэл 1, 2, 3-д уншсан бүх төслүүд бол байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийгдэж байгаа. Яг энэ хуулиараа ерөнхий үнэлгээний үед сум болон дүүргийн Засаг даргаас холбогдох мэдээллийг албан бичгийг авч ерөнхий үнэлгээ бол хийгддэг ээ.

Тэгэхээр яг энэ ерөнхий үнэлгээний үед сум, дүүргийн орон нутгийн оролцоо тэндээс бол хангагдаад явдаг байгаа. Ерөнхий үнэлгээ дээр зэрэглэл 1, 2, 3-аасаа хамаараад, ер нь цар хүрээнээсээ хамаараад нарийвчилсан үнэлгээ хийх үү, үгүй юү гэдгийг шийддэг.

Нарийвчилсан үнэлгээ хийх гэж байгаа тохиолдолд мэргэжлийн байгууллага нөлөөллийн бүсийн иргэдийг тогтоож байгаа. Энэ хууль дээр бас 10.5 дугаар зүйл дээр бүгдээрээ санал хураах үеэр харагдана. Энэ хуулийн нэг гол зүйл нь мэргэжлийн байгууллагуудын үүргийг нь нэлээн сайн оруулж өгсөн байгаа. Өөрсдийнхөө хийсэн байгаа тайлан, нарийвчилсан үнэлгээгээ, нөлөөллийн бүсийн иргэд нөлөөллийн бүс гэж тодорхойлтод орсон тэнд амьдарч байгаа иргэдэд өөрсдөө очиж нутгийн захиргааныхаа байгууллагын хүмүүстэйгээ хамтдаа танилцуулаад яв аа гэдгийг нь үүрэгжүүлж өгсөн ийм давуу талтай байгаа. Тэгэхээр ерөнхий үнэлгээний үед бол дүүрэг, сумын нутгийн захиргааны

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байгууллагын оролцоо орж ирнэ. Яг нарийвчилсан үнэлгээний хувьд бол иргэнийхээ нөлөөллийн бүсийн иргэний саналыг нь тусгадаг байя гэсэн концепцтойгоор орж ирсэн хууль байгаа.

**Б.Бейсен:** Ганхүлэг гишүүн тодруулъя.

**М.Ганхүлэг:** Яг бас тодорхой хариулт авч чадахгүй байгаад байна аа. Ингээд Засгийн газар дээр аль нэг сайд нь яах вэ мэдээд тухайн төслийг зэрэглэл бууруулах ийм боломжтой байх уу гэж асуугаад байна л даа. Тэгээд одоо тэр чинь амьдрал баялаг. Ингээд янз янзын байдлаар тайлбарлаад л гоё янз янзын байдлаар хэлээд л тэгээд нөгөө маш их өндөр эрсдэлтэй ийм төслийг дунд эрсдэл рүү оруулж ирээд ингээд бас завааруулаад явчих ийм бас байдлыг бий болгочих вий дээ. Энэ дээр яг ямар хаалт байгаа юм бэ? Энийг үндсэндээ яаж зохицуулах юм бэ гэдэг асуулт байгаад байна л даа.

Хоёрт нь энэ зэрэглэл рүү энэ энэ төслүүд орно оо гэдгийг яг баг дээр байгаа иргэн яаж энд саналаа өгөх юм бэ гэдгийг тодорхой асуугаад байна л даа.

**Б.Бейсен:** 5 номер хариулъя.

**Ц.Уранчимэг:** Засгийн газраар оруулж байгаа тогтоолын төсөлд бол зэрэглэл 1, 2, 3-ыг яг саяын нөгөө бүрдэл Дэлхийн банкны олон улсын бас аргачлал тэгээд яг энэ нөлөөллийн бүсийг тогтоосон аргачлалыг яг тодорхой яг аргачлалын дагуу Засгийн газрын яг оруулж байгаа журмаараа бол нэлээн дэлгэрэнгүй батлаад өгчхөж байгаа. Тэгэхээр Засгийн газар дээр орсон тогтоолыг бол одоо мэргэжлийн байгууллага өөрчлөөд явах боломжгүй.

Гэхдээ иргэдэд саналаа танилцуулахад бол мэргэжлийн байгууллага нь өмнө нь төсөл хэрэгжүүлэгч өөрөө яг энэ нөгөө зэрэглэлээ тогтоочоод тэр саналаа танилцуулга, бүх нөлөөллийн бүсийн үйл ажиллагаа мөн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлт хийсэн бүх тайлангаа танилцуулж байж саналаа авна. Энэ дээр бол байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээний бүх шалгуур үзүүлэлтийг хангаад нөлөөллөө тогтоосныхоо дараа яг иргэдэд саналаа танилцуулаад иргэдийн саналыг тусгах байдлаар яг аваад ингээд яв.../минут дуусав./

**Б.Бейсен:** Мандхай гишүүн асуулт асууя.

**М.Мандхай:** Энэ хууль дээр асуулт давхцаж байсан учраас бас өөр нэмээд асуулт асуучихъя гэж бодож байна. Энэ нөхөн сэргээлт хийнэ гээд энэ ерөнхийдөө бизнесүүд дээр нөхөн сэргээлт хийнэ ээ гэххээд хийхгүй байгаад байгаа ялангуяа нөгөө уул уурхайн бизнесүүд дээр нөхөн сэргээлтээ хийхгүй байгаад байдаг ийм эрсдэлүүд бол практик дээр олон бий. Тэгэхээр энэ хуулийн шинэчлэлээр яг энэ нөхөн сэргээлтийг хийхтэй холбоотой яг ямар хатуу зохицуулалтуудыг тусгаж оруулж өгч байгаа вэ? Яагаад гэхлээр ингээд ангиллын түвшин 3 түвшингөөр буураад эхэлдэг. Нэг талаараа бас хяналтын буюу чанарын хяналтын түвшин бас буурах ийм эрсдэлтэй харагдаад байдаг.

Нөгөө талдаа ялангуяа энэ уул уурхайн чиглэлийн үйл ажиллагаа дээр нөхөн сэргээлттэй холбоотой энэ асуудлыг ер нь хэрхэн зохицуулж байгаа вэ гэдэг дээр асуулт асууя. Одоо бол хууль дээр болохоор нөхөн сэргээлтийн

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

менежментийн төлөвлөгөөний 50 хувьтай тэнцэх дүнг 9.9 дээр байсан санагдаад байна хэр бодитой ер нь бас үнэлгээ гэж үзэж байгаа вэ гэдэг асуулт байна.

Хоёрт нь болохоор энэ 8.9, 8.10 дээр байгаад байгаа Засгийн газрын энэ ангиллаар нь, уучлаарай эхний зүйл дээр дараагийнх дээр нь асуучихъя. Эхлээд нөхөн сэргээлттэй холбоотой энэ асуултыг тодруулаадахъя.

**Б.Бейсен:** Нэмж 6 номер хариулъя.

**Ш.Батбаяр:** Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Төрийн нарийн бичгийн дарга Батбаяр гишүүний асуултад хариулъя. Энэ хууль дээр бол шинэчилсэн найруулга дээр бол байхгүй байгаа. Өмнөх хуучин хэлбэрээрээ явж байгаа байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 50 хувь дахь, 50 хувьд ноогдох зардлыг санд байршуулна аа гэж заасан байгаа. Энэ нөхөн сэргээлтийн санд байршуулна аа гэж заасан байгаа. Байгаа.

**Б.Бейсен:** 5 номер нэмж хариулъя.

**Ц.Уранчимэг:** Одоо орж ирж байгаа нэмэлт, өөрчлөлт дээр бол байхгүй. Одоо мөрдөгдөж байгаа хуулиараа бол явж байгаа. Хэвээрээ явж байгаа гэсэн үг. Тэгэхээр яг одоо байгаа хуулийн хэрэгжилт нь бол техникийн болон биологийн нөхөн сэргээлт явж байгаа. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө яг энэ байгаль орчны нарийвчилсан үнэлгээгээ дагаад менежментийн төлөвлөгөөг 5 жилээр баталдаг. Тухайн жилийн төлөвлөгөөг байгаль орчин яг адилхан явна.

Тэгэхдээ яг нөхөн сэргээлтийн таны саяын, бас сүүлд цохон тэмдэглэж байгаа асуудал бол үнэхээр чухал. Яг энэ нөхөн сэргээлт нь яг бодит болж байгаа юу, үгүй юү гэдэг нь уулын ажлын төлөвлөгөө буюу менежментийн төлөвлөгөөндөө тусгагдаад явдаг.

Тэгэхдээ ихэвчлэн уул уурхайн компаниуд илүү техникийн нөхөн сэргээлтийг сонгоод явчихдаг учраас одоо бид нар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны журмаар биологийн нөхөн сэргээлтийг зайлшгүй хийхийг тодорхой бүс нутгууд дээр шууд зааж өгч явж байгаа учраас биологийн нөхөн сэргээлт нь дүйцүүлэн хамгаалал бусад яг тэр журмаар зохицуулсан үйл ажиллагааг мөрдөх ёстой. Тэгээд энэ менежментийн тухайн жилийн менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн.../минут дуусав./

**Б.Бейсен:** Гүйцээж хариулъя 5 номер.

**Ц.Уранчимэг:** Тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтийг хянадаг, эргээд тухайн жилийн төлөвлөгөөг нь зарцуулсан зарцуулалт хөрөнгө оруулалтыг нь тайланд нь тусгаад явдаг учраас тэр дээр нь бол нарийн хяналтыг тавиад явж байгаа.

**Б.Бейсен:** Уянгаа гишүүн нэмж хариулъя.

**Б.Уянга:** Мандхай гишүүний асуулттай бол агуулгын хувьд Ашигт малтмалын тухай хууль дээр нэлээн сайн ажиллах ёстой юм билээ. Яг одоо энэ засгаас өргөн баригдсан энэ Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хууль дээр болохоор менежментийн төлөвлөгөөний асуудлыг сайд өөрөө чанарын тал дээр

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нь журмаараа батална аа л гэж орж ирснээс биш яг дотор нь бол орж ирсэн зүйлүүд байхгүй юм. Яг уул уурхайтай холбоотой хэсэг нь болохоор Ашигт малтмалын тухай хууль өргөн баригдах үеэр угаасаа яамнаас уул уурхайн хаалт, нөхөн сэргээлт гээд тусдаа бүлэг оруулж ирж байна лээ нэлээн дэлгэрэнгүй. Энэ дээр нь хамтарч ажиллая.

**Б.Бейсен:** Мандхай гишүүн тодруулъя.

**М.Мандхай:** Тэгэхээр Ашигт малтмалын тухай хууль дээр нэлээн нарийвчилж оруулж ирж байгаа ч гэсэн нөгөө талдаа энэ чинь нөгөө байгаль орчиндоо бас шууд хамааралтай асуудал учраас хэрэв уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явж байгаа аж ахуйн нэгж хариуцлагагүй байдлаар нөхөн сэргээлтээ яг зохих стандартын түвшинд хийж чадахгүй байх юм бол байгаль орчны энэ бодлого хариуцаж байгаа газар холбогдох энэ газрууд яг ямар энэ зохицуулалт, хариуцлага, хариуцлагын механизмыг хэрэгжүүлэх юм бэ гэдгийг л би тодорхой асуугаад байгаа нь л юм л даа.

Ер нь бол яах вэ энэ дээр чинь мөнгөн хөрөнгийг тус сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагна гэдэг бол тодорхой зохицуулалт байгаад байгаа байхгүй юу тээ? Тэгэхээр Уул уурхайн яам руу шилжүүлчихээр Ашигт малтмалынхаа тухай хууль гэхихээр байгаль орчны, энэ яг энэ байгаль орчинд нөлөөлөх байдлын энэ өөрөө.../минут дуусав./

**Б.Бейсен:** Хэд номер хариулах вэ? 6, 5 номер.

**Ц.Уранчимэг:** Яг энэ дээр Мандхай гишүүний асуултад хариулъя. Та аягүй чухал асуудал хөндөж байна. Энийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар бол яг байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээ, тайлангаа хийж батлуулаад тэрийгээ дагаад байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө батлаад уурхайн хаалтын гэрээгээ хийгээд явдаг. Байгаль орчныг хамгаалах хуулийн 10-ын штрих дээр байгаль орчны аудит 2 жил тутам 1 хийлгэх зайлшгүй ийм зохицуулалт байдаг боловч энэ хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа учраас яг энэ нөхөн төлбөр тавих, хохирол тооцох тэр барьцаа хөрөнгөд байгаа асуудлыг буцааж зарцуулах асуудал нь яг орхигдчихоод яваад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр яг энэ байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээрээ менежментийн төлөвлөгөө, тайланг нь баталж өгөөд байдаг. Байгаль орчныг хамгаалах хуулиараа байгаль орчны аудитыг ерөөсөө хийлгэж явдаг яг энэ дээр хяналт тавьдаг тогтолцоо нь бас хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь энэ зохицуулалтыг алдагдуулаад байгаа юм. Тэрнээс биш яг нөгөө Уул уурхайн яам эргээд энэ дээрээ хяналт тавих гэдэг асуудал биш. Уул нь бол яг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын.../минут дуусав.

**Б.Бейсен:** 6 номер нэмж хариулъя.

**Ш.Батбаяр:** Нэмэлт тодруулга өгье өө. Тэгээд гишүүний асуусан асуултад дурдагдаж байгаа энэ экологи, эдийн засгийн хохирлыг хэрхэн зөв үнэлж байгаа вэ гэдэг дээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Хууль зүйн яамны

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хамтарсан журам байгаа. Байгаль экологид учруулсан хохирлын үнэлгээ хийх журам байгаа. Энийг яамнаас бол шинэчлэн боловсруулж байгаа. Бас үнэлгээ зарим цаг хугацааны явцад бол зарим үнэлгээг бас шинэчлэн сайжруулах шаардлага бас зайлшгүй гарсан байгаа.

Мөн хоёрдугаарт энэ байгаль орчны хохирлын үнэлгээ хийж байгаа үнэлгээний компаниудыг бас чадавхжуулах, хийж байгаа үнэлгээг нь бас яг бодит хохиролтой нийцүүлэх тал дээр бас яамнаас тодорхой арга хэмжээнүүдийг авахаар төлөвлөн ажиллаж байгаа. Компаниуддаа бас шалгуур үзүүлэлтийг бас сайжруулъя, аттестатчилал хийе, зарим нэг чадахгүй компаниудын зөвшөөрлийг цуцлах зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

**Б.Бейсен:** Би нэг асуулт асууя. Энэ аюултай хог хаягдлын байгальд нөлөөлөх нөлөөллийн талаар ер нь сая Мандхай гишүүний саналыг бас дэмжиж байна. Энэ уул уурхайн компаниуд дахин боловсрох үйлдвэр байхгүй газрын моторын хаягдал тосыг плёнк газар хучаад, плёнк дэвсэж байгаад асгаж байна гэсэн. Энэ одоо хэр байна энийг яаж шийдэх вэ? Ер нь зөвхөн энэ асуудал биш нөгөө химийн хог хаягдлын асуудал байна. Энэний нөлөөллийг яаж тусгаж байна, энэ тайлан дээр яаж тусгах вэ энийг?

7 номер уу? 6 номер. Алтанзул дарга.

**Б.Алтанзул:** Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн дарга Алтанзул байна. Бейсен даргын асуултад хариулъя. Үнэлгээний тайланд бол сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор энэ уул уурхайн үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын энэ аюултай хог хаягдлыг бол мэргэжлийн байгууллага буюу энэ аюултай хог хаягдлыг дахин боловсруулдаг компаниудтай гэрээтэй ажилладаг. Энэний дагуу нь бол тухайн компани аюултай хог хаягдлыг тээвэрлэх, хадгалах, устгах үйл ажиллагааг эрхэлж байгаа. Тухайн нөхцөл байдалд зарим яг энэ шууд байгальд асгах ийм тохиолдлууд бий. Энийг нь салбарын хяналт бол хяналтаа хийгээд холбогдох арга хэмжээ, хариуцлагыг тооцоод явагдаж байгаа.

Үнэлгээний тухай хуулийн дагуу үнэлгээний тайланд туссан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд зөвлөмжийг бол яг энэ мэргэжлийн байгууллагад хандаж, гэрээ байгуулж энэ аюултай хохирлыг устгуулах чиглэлээр тайланд заавал тусгуулдаг. Хариулт дууслаа.

**Б.Бейсен:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ажлын хэсгээс ирүүлсэн 3 санал байгаа. Жагсаалтын дагуу уншиж танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.9.Төслийг байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, цар хүрээ, төсөл хэрэгжих газар нутгийн байршил, хүчин чадлыг харгалзан дараах байдлаар ангилна.Үүнд:

7.9.1.зэрэглэл I буюу их эрсдэлтэй төсөлд байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх сөрөг болон хуримтлагдах нөлөөлөл нь төслийн нөлөөллийн бүсийн хэмжээгээр хязгаарлагдахгүй, байгаль орчин, нийгмийн сөрөг

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нөлөөллийг бууруулахад нэмэлт арга хэмжээ шаардлагатай, газар чөлөөлөлтийн хамрах хүрээ ихтэй үйл ажиллагааг;

7.9.2.зэрэглэл II буюу дунд эрсдэлтэй төсөлд байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь төслийн нөлөөллийн бүсийн хэмжээгээр хязгаарлагдах боломжтой, байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулахад нөхцөл, болзолтой арга хэмжээ шаардлагатай, газар чөлөөлөлтийн хамрах хүрээ хязгаарлагдмал үйл ажиллагааг;

7.9.3.зэрэглэл III буюу бага эрсдэлтэй төсөлд байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл хязгаарлагдмал, эсхүл эрсдэлгүй үйл ажиллагааг.” ийм санал ирсэн байна. Санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлдээрэй.

Санал хураалт 61.1 хувиар дэмжигдлээ.

Хоёр дахь санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.13.Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны ерөнхий үнэлгээнд санал авах хүсэлтийг төслийн товч танилцуулга, газрын эрхтэй холбоотой баримт бичгийн хамт тухайн сум, дүүргийн Засаг даргад гаргана.”

Чинбүрэн гишүүн.

**Ж.Чинбүрэн:** Ажлын хэсгийнхнээс нэг зүйлийг тодруулж асууя. Ер нь ийм үнэлгээ хийхдээ хараат бус байдлыг хэр тогтоож чадаж байгаа вэ, олон нийтийн оролцоо энд байгаа юу, хараат бус байдлаар үнэлгээ өгч чадаж байгаа юу гэдэг дээр яаж энэ заалт дээр орж байгаа вэ? Засаг дарга дангаараа томилох юм уу энэ дээр хариулт өгөөч.

**Б.Бейсен:** Хэдэн номер хариулах вэ? 5 номер.

**Ц.Уранчимэг:** Хараат бус байдал гэдгийг нэлээн тодорхой оруулж өгч байгаа. Өмнө нь бол манай байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ нь бараг ижил түвшинд санал авч орж ирдэг байсан. Тэгэхээр одоо байгаль орчны ерөнхий үнэлгээгээрээ яг энэ зэрэглэлээ тогтоогоод ялангуяа 3 дугаар зэрэглэл дээр бол заавал Засаг даргын хороо хорины санал биш ер нь бизнес төлөвлөгөө, газрын зөвшөөрөл, шалгах хуудас, боомтын төлөвлөгөөтэйгөө орж ирэх юм бол хялбаршуулсан байдлаар шууд ингээд байгаль орчны ерөнхий үнэлгээ болон нарийвчилсан үнэлгээгээ батлаад ерөнхий үнэлгээ батлаад явах боломжтой байдлаар явж байгаа.

Тэгэхгүй бол уул уурхайн төсөлтэй адилхан зүгээр үсчний газар жишээлбэл заавал нарийвчилсан үнэлгээ хийх ийм процесстой байна аа гэдэг бол маш олон санал, гомдол гардаг учраас энэ дээр явж байгаа.

Хоёрдугаарт бас яг ингээд 1, 2 дугаар зэрэглэлийн нарийвчилсан үнэлгээний төсөл дээр ИНХ-ын тогтоол саналыг заавал ИНХ хуралдаж байж заавал тогтоол гарч байж санал нь орж ирдэг байсан бол одоо яг нөлөөллийн

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

бүсэд байгаа иргэдийн саналыг тусгаж санал авч танилцуулгыг оруулж ирнэ ээ гэдэг байдлаар нэмэлт, өөрчлөлт орж байгаа.

**Б.Бейсен:** Санал хураалт. Хоёр дахь санал 55.6 хувиар дэмжигдлээ.

Гурав дахь санал.

Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.14 дэх хэсгийн “ажлын 10 хоногт” гэснийг “ажлын 15 хоногт” гэж, “хариу өгсөнд” гэснийг “зөвшөөрсөнд” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт.

Санал 61.1 хувиар дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Сэддоржоос 2 санал ирүүлсэн байна. Саналыг уншиж танилцуулъя. Саналын томъёолол.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 18.7-д заасан “Иргэн тухайн төслийн үйл ажиллагаатай холбогдуулан газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаарх мэдээлэл авах, танилцах хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгчид гаргаж болно.” гэснийг “Иргэн тухайн төслийн үйл ажиллагаатай холбогдуулан газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаар мэдээлэл авах, танилцах хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгч төрийн байгууллага, албан тушаалтанд гаргаж болох бөгөөд төслийн нөлөөлөлд өртөх иргэдийн олонхын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр байгаль орчны нөлөөллийн үнэлгээг эергээр дүгнэхийг хориглоно.” гэж өөрчлөн найруулах гэсэн байна.

Чинбүрэн гишүүн асуулт асууя.

**Ж.Чинбүрэн:** Бид хариуцлагын механизмыг илүү их сайжруулах ёстой л доо. Тэгэхлээр бас ажлын хэсгийнхнээс нэг асуух гэж байгаа зүйл хэрвээ хуурамч, дутуу үнэлгээ хийсэн бол зөвхөн тэр үнэлгээ хийлгэхээр өгсөн компани хариуцахаас гадна энэ үнэлгээ хийсэн байгууллага давхар хариуцдаг байх энэ механизм байна уу? Зөвхөн компани өөрөө үнэлгээ хийлгүүлчхээд тэр нь зөв гээд хэлчихсэн байдаг. Тэгсэн тэр нь худлаа байвал үнэлгээ хийсэн байгууллагатай хариуцлага тооцох ийм механизм байгаа юу?

**Б.Бейсен:** Хэдэн номер хариулах вэ? Алтанзул дарга 6 номерын микрофон.

**Б.Алтанзул:** Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Үнэлгээ, аудитын хэлтсийн дарга Алтанзул. Одоогийн мөрдөж байгаа эрх зүйн зохицуулалтын хүрээнд бол мэргэжлийн байгууллага өөрийн итгэл үнэмшил, дотоод зохион байгуулалт, мэргэжлийн чадварлаг шинжээчийн хүрээнд үнэлгээний тайлан боловсруулж гаргаж байгаа. Үнэлгээний тайланг бол яам хянаад баталгаажуулах арга хэмжээг авч байгаа. Энэ бол Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэж явж байгаа.

Хэрвээ энэ хяналтын процесс нь бол 2, 3 шатаар явж байгаа яг өнөөдрийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд. Эхлээд шинжээч энийг, мэргэжлийн шинжээч, яамны хариуцсан шинжээч хянаж байгаа. Тайлан дээр хуулийн шаардлага хангаж

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байгаа эсэх болон Засгийн газрын тогтоолоор баталсан дүрэм, журам, сайдын тушаалаар баталсан дүрэм, журмын хүрээнд нийцэж байгаа эсэх дээр дүгнэлт гаргадаг. Ингээд шаардлага хангаагүй бол буцааж байгаа. Буцаагаад мэргэжлийн байгууллага дахиад засвараа хийгээд одоо ингээд та бүгдийн хийсэн, өгсөн шүүмжийн дагуу бид нар засвараа хийлээ гэдгийг илтгээд буцаагаад цахимаар илгээдэг. Энийг дахиж шинжээч хянаад тухайн алба, хэлтэст хянуулаад ингээд мэргэжлийн зөвлөлийн хуралд танилцуулж байгаа. Мэргэжлийн зөвлөлийн хурал дээр бол мэргэшсэн шинжээч нар 15 шинжээч бий. Энэ шинжээч нар бол чиглэл чиглэлээрээ, ус нь усаараа, ой нь ойгоороо, хөрс нь хөрсөөрөө, ургамал нь ургамлаараа чиглэл бүрийнхээ асуудлаар шүүмж өгч дүгнэлт гаргадаг. Ингээд хурлаар бол энийг олонхын саналаар хэлэлцэж баталдаг. Хяналтын горимд бол ингэж явж байгаа.

Хэрвээ шаардлагатай тохиолдолд Мэргэжлийн зөвлөлийн хурал бол хурлаас шууд буцаадаг. Дахиж тайлан боловсруулах үүрэг өгч буцаадаг. Эцэст нь ингээд.../минут дуусав.

**Б.Бейсен:** Чинбүрэн гишүүн тодруулъя.

**Ж.Чинбүрэн:** Шинжээч мэргэжлийн зөвлөлөөр оруулахдаа худал мэдээлэл өгч оруулсан бол тухайн компани болон тэр мэргэжлийн дүгнэлт өгч оруулж ирсэн мэргэжилтэн юм уу байгууллагатай хариуцлага тооцдог, дахиж ийм үйл ажиллагаа хийх эрх энэ тэр нь хасдаг барьдаг зүйл байна уу гэж асууж байхгүй юу.

**Б.Бейсен:** Эхлээд 5 номер хариулъя. Дараа нь 6 номер Алтанзул дарга хариул.

**Ц.Уранчимэг:** Чинбүрэн гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Одоо байгаа дагаж мөрдөж байгаа хуулийн 11 дүгээр зүйл дээр хянан магадалгаа гэж байгаа. Яг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсний үндсэн дээр төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгж, байгууллага хүний эрүүл мэнд байгаль орчинд хохирол учруулж байгаа болон учруулсан бол үнэн, зөвөө хийгдсэн эсэхэд нь хянан магадалгааг хийнэ. Яг энэ зүйл дээр болохлоор хэрвээ хянан магадалгаа дахиж хийгээд нарийвчилсан үнэлгээ нь буруу гэсэн тохиолдолд одоо энийг хийсэн компани мөн яг энийг хийж байгаа мэргэжлийн байгууллагын эрхтэй компанийн эрхийг бол цуцлах төрийн захиргааны байгууллага түдгэлзүүлэх ийм шийдвэр байгаа. Яг энэ хохирол, хэрвээ энэ хянан магадалгаа нь бүрэн төсөл хэрэгжүүлэгч өөрөө бас яг энийгээ ТЭЗҮ-ээ батлуулахдаа буруу батлуулаад байгаль орчинд нөлөөлөх менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тодорхой хэмжээний зардал, төсвөө суулгаагүй, нөлөөллийг ТЭЗҮ дээрээ тодорхой гаргаагүй байх юм бол байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэл.../минут дуусав.

**Б.Бейсен:** Уранчимэг гүйцээж хариулъя.

**Ц.Уранчимэг:** Буруу хийгдэх тохиолдлууд маш их байдаг. Тэгэхээр яг энэ байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны төлөв байдлын үнэлгээг хийхдээ ТЭЗҮ дээр энэ том төслүүдийг илүү хийдэг учраас энэ хариуцлагын хүрээнд бол яг Зөрчлийн хуулиараа бас тодорхой санкцуудыг өгөөд явдаг. Гэхдээ өнөөдрийн байгаа Зөрчлийн хуулийн санкц нь бол 500 хүртэл төгрөгөөр торгодог

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

учраас бас учир дутагдалтай байгаа. Тэгэхдээ яг хянан магадлалаараа бид нар бол энийг нэмэлтээр хийгээд өөрчлөлт оруулаад явах бүрэн боломжтой.

Тэгээд Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний 1, 2, 3 дугаар зэрэглэл дээр бас энэ асуудлыг шинэ хуулийн заалтаар бол нэмж бас тодорхой зааж өгсөн байгаа.

**Б.Бейсен:** Алтанзул дарга хариулъя нэмж. Дараагаар нь Ганхүлэг гишүүн асуулт асууя.

**Б.Алтанзул:** Гишүүний асуултад хариулъя. Яг өнөөдрийн байдлаар бол амьдрал дээр бас яг энэ бичиг баримт хуурамчаар үйлдэх ийм тохиолдол бол 1 гарсан. Тухайлбал, Баянхонгор аймаг дахь төслийн хүрээнд 2 багийн ИНХ-ын тэмдэглэлийг хуурамчаар үйлдээд, хуурамч гарын үсэг зураад өөр багийн тэмдэг дарчихсан байсан. Энийг нь бол бид нар энийг бол нотлох үүрэггүй. Гэхдээ бид нар энийг тодруулаад хуулийн байгууллагад шилжүүлсэн. Арга хэмжээ авч байгаа.

Үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллагыг нь бид нар эрхийг нь цуцалж байгаа. Ийм арга хэмжээ авч байгаа.

**Б.Бейсен:** Чинбүрэн гишүүн тодруулъя.

**Ж.Чинбүрэн:** Яг одоо энэ их хариуцлагатай асуудал л даа гишүүд ээ. Тэгэхлээр манай Байнгын хорооны гишүүдээ анхаараарай. Жишээлбэл, Туул голын энэ хурдны замтай холбоотой ТЭЗҮ нь яаж гарсан юм, үнэхээр байгаль орчинд нөлөөлсөн юм уу, нөлөөлөөгүй юм уу гээд л энэ асуудал бас их ноцтой байхгүй юу. Тийм учраас бид энийг зайлшгүй ингэж ярьж тэр буруу гаргаж байгаа, худал мэдээлэл өгч байгаа байгаль орчинд ямар нэгэн сөрөг нөлөөгүйг энэ тэр гэсэн нь хэрвээ худлаа байх юм бол хэн хариуцлага хүлээх вэ гэдэг асуудлыг л би сайн тодруулж ярьж байгаа шүү. Тийм, энэ бол маш ч чухал яригдаж байгаа зүйл ээ гэж бас анхаараарай.

**Б.Бейсен:** Ганхүлэг гишүүн асуулт асууя. Түрүүчийн юун дээр Бат-Эрдэнэ гишүүн, Замира гишүүн 2-ыг дэмжсэнээр аваарай.

**М.Ганхүлэг:** Сэддорж гишүүний олон нийтийн оролцоотой холбогдолтой бүлэг хэсэг дээр оруулж ирж байгаа саналыг ерөнхийдөө бол яах вэ дэмжиж байна. Агуулгын хүрээнд төслийн тодорхой явж байгаа үр нөлөө эдгээр зүйлүүд дээр үнэлэлт хийгээд иргэд гарын үсэг зурахаар зөвхөн танилцуулах гэдгээр ямар ч цаг үед төсөлтэй холбогдолтой нарийн мэдээллийг танилцуулах гэдгээр орж ирж байна уу, илүү нарийвчилсан өөр зохицуулалт байна уу гэдгийг дахиад тодруулчихъя.

Үүнтэй холбогдолтой тэр олон нийтийн санал, асуулттай холбогдолтой энэ хууль өмнө нь бас орж ирсэн. Тэгээд ИНХ-ын энэ байгаа чиг үүрэг чинь бол уул нь бол засаг захиргааны нэгж болон энэ бүтцийнхээ хувьд бол албан ёсны шийдвэр гаргах манай үндсэн шийдвэр болоод байна шүү дээ. Гэтэл энэ шийдвэрийг болиулаад нөлөөллийн бүс гээд ингээд нэрлээд ингээд явахаар чинь нөгөө олон нийтийн хяналт олон юмнаасаа бас ухарсан ийм ийм байдал руу бол орох гээд байна аа гэж өмнөх Байнгын хороогоор орж ирэхэд нь бид нар нэлээн шүүмжилсэн. Тэгээд энэ дээр манай Байнгын хорооны гишүүд бас нэлээн онцгой

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

анхаарал хандуулах ёстой юу болж байна. Тэгэхээр нөлөөллийн бүс гэхээр яах вэ 2 айлаас санал аваад яг болчих юм уу? Хэчнээн айл байгааг яаж тогтоох юм? Багийн түвшиндээ үндсэндээ байгаа иргэдээсээ саналаа аваад хурлаа хийгээд нэгдсэн ИНХ гэдэг бол тодорхой тэр багийн түвшинд шийдвэр гаргаж байгаа хамгийн чухал нэгж. Үүнээс доош дахиад нөлөөллийн бүс гээд ингээд жижиглэсэн ийм хэлбэр гаргаж ирээд ингээд явах юм. Цаад зорилго нь бол бас тийм юугүй л болгоод байна л даа иргэд, олон нийтийн энэ олон нийтийн хяналтыг улам л бууруулж байгаа, суллаж байгаа л ийм нөхцөл байдал болж байна л даа. Тэгэхээр уул нь бол одоо иргэд олон нийтийн хувьд бол хүртэж байгаа үр өгөөжөө сум, орон нутагтаа илүү өгөөд байх юм бол энэ төслүүдийг дэмжээд явах ийм л хандлагатай байгаа шүү дээ.

Гэхдээ нүдэн дээр нь ямар ч үр өгөөжгүй тэгээд байгаль дэлхий энэ олон зуун жил ирсэн энэ байгаль дэлхий нь сүйдээд эхлэхээр тэр дээрээ хяналтаа тавих энэ байдал нь улам ингээд буураад эхлэхээр улам л зөрчил рүүгээ л явах санагдаад байх юм. Тэгээд яах вэ бид нар хүчээр ингээд шийдчихэж болно. Тэгэхдээ иргэдийн эсэргүүцэл олон зүйл тэгээд л байсаар л байна. Тэгэхээр энийгээ та хэд маань яаж харж байгаа юм? Тэгээд иргэдийн хурлаар шийдэхгүй болоод эхлэхээр ард түмэн дуугүй болчихно гэж бодоод байгаа юм уу, нөлөөллийнхөө бүсийг яаж хийнэ гэж бодоод байгаа юм гээд энийг жоохон дахиад олон нийт дээр.

**Б.Бейсен:** Ажлын хэсгийн ахлагч Уянгаа гишүүн хариулъя.

**Б.Уянгаа:** Сэддорж гишүүнээс Байнгын хороонд 4 санал ирсэн. Тэгээд яг үндэслэл гэдэг дээр нь тайлбар байхгүй байгаа учраас яг Сэддорж гишүүний өмнөөс бол хариулах боломжгүй. Гэхдээ яах вэ яг саналыг нь нарийн үзэхээр эхний сая Бейсен даргын уншсан санал дээр бол зөвшөөрөл гэдэг үг гарч ирж байгаа юм. Тэгээд нөлөөллийн үнэлгээг эергээр дүгнэхийг хориглоно оо гээд. Энэ бол нөгөө мэргэжлийн байгууллагын эрх хэмжээ рүү яваад орчхож байгаа юм.

Тэгэхээр яг зүгээр уншсан түвшиндээ болохоор дэмжихэд их хүнд ийм л байна. Тэгээд Зөвшөөрлийн тухай хууль бас энэ хуулийн төсөлд хөндөгдөж орж ирээгүй. Тийм учраас одоо байгаа яг хүчин төгөлдөр байгаа хууль дээрээ хүртэл санал, тэмдэглэл гэсэн үгийг тогтоол болгон явчихсан энэ нормыг энэ чинь Иргэдийн хурлын тогтоолоор санал авах биш иргэдээс нь санал авах гэдэг нь 2012 оны энэ хуулийн амин сүнс нь юм аа гэдэг дээр илүү нарийвчлаад нөлөөллийн бүс гэдгээр нь найруулж орж ирж байгаа юм билээ.

Энэ нөлөөллийн бүсийг болохоороо мэргэжлийн байгууллага тодорхойлдог. Тэгэхээр хэрвээ дэд бүтцийн зам байлаа гэхэд замын трассаасаа 2 тийшээ хэдэн километр нь шууд нөлөөллийнх, тэгээд дам гээд манай ажлын хэсэгт бас яг энэ чиглэлийн нарийвчилсан үнэлгээг гаргадаг судлаачид байгаа учраас надаас илүү хариултуудыг бол өгч чадна.

Тэгэхээр нөлөөллийн бүсээ мэргэжлийн байгууллага нь тодорхойлчихоод одоо энэ ажлын хэсгийн ажилласан 10.5 гэдэг заалт дээр болохоор нутгийн захиргааны байгууллагаасаа хүнтэй тэгээд яг тэр нарийвчилсан үнэлгээг хийсэн мэргэжлийн байгууллагын хүн нь бас өөрөө нөгөө Чинбүрэн гишүүн бас мэргэжлийн байгууллагын хариуцлага ярьсан яг энэ 10.5 гэсэн заалтаар л бид нар мэргэжлийн байгууллага нь өөрсдөө ажлаа хийгээд тайлбарлаа аа гэж байгаа.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тэгэхээр иймэрхүү байдлаар нөлөөллийн бүсдээ хүрч ажиллах юм бол илүү их дэмжлэгийг авах юм байна аа гэж л ажлын хэсэг дээр ажилласан даа.

**Б.Бейсен:** Баярлалаа. Санал хураалт. Томьёоллыг уншсан билүү? Санал хураалт.

22.2 хувиар санал дэмжигдээгүй.

2 дахь санал. Саналын томьёолол.

1 дүгээр зүйлийн хуулийн төслийн 7.14-д нэмэлтээр орж буй сум, дүүргийн Засаг дарга нь төсөл хэрэгжүүлэгчээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, ажлын 10 хоногт багтаан хариу өгөх бөгөөд энэ хугацаанд шийдвэрлээгүй тохиолдолд хариу өгсөнд тооцно гэсэн заалтыг хасах. Санал хураалт.

22.2 хувиар санал дэмжигдээгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрс өгнө үү?

Асуулт асуух гишүүд байхгүй байна. Энэ дээр ажлын хэсгээс ирсэн санал.

Төслийн 2 дугаар зүйлийн “3.1.4 дэх заалтын “үнэлгээ гэж” гэсний дараа “зэрэглэл I, зэрэглэл II” гэж,” гэснийг, төслийн 4 дүгээр зүйлийн “3 дугаар зүйлийн 3.1.4 дэх хэсгийн “байгаль орчны” гэснийг “байгаль орчин, нийгмийн” гэж,” гэснийг болон төслийн 5 дугаар зүйлийг хасаж, 3.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж төслийн 3 дугаар зүйлд нэмэх:

“3.1.4.“байгаль орчны төлөв байдлын үнэлгээ” гэж зэрэглэл I, зэрэглэл II төслийн техник, эдийн засгийн төлөвлөлтийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн төлөв байдлыг судлан тогтоож цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлохыг;” гээд заасан байна. Санал хураалт.

Энэ санал дэмжигдсэнгүй 44.4 хувиар. Замира гишүүний микрофоныг өгье.

**С.Замира:** Уучлаарай. Горимын санал гаргамаар байна. Сая энэ санал хураалтыг хүчингүй болгоод дахиж санал хураалт хийж өгнө үү гээд. Төхөөрөмж сая ажилласангүй.

**Б.Бейсен:** Замира гишүүний саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

61.1 хувиар дэмжигдсэн тул дахин санал хураалт явуулъя. Санал хураалт.

61.1 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрс өгнө үү?

Асуулт асуух гишүүн байхгүй байна. Ажлын хэсгээс ирсэн 4 санал байгаа.

6.Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.6.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ерөнхий шинжээч, шинжээчийн эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага олгох бөгөөд тэдгээр нь дараах шаардлагыг хангасан байна:

7.6.1.ерөнхий шинжээч нь Төрийн албаны тухай хуулийн 23.2.2-т заасан шаардлагыг хангасан, байгаль орчны чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байх;

7.6.2.шинжээч нь Төрийн албаны тухай хуулийн 18.1.4-т заасан шаардлагыг хангасан, байгаль орчны чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байна.”. Санал хураалт.

Санал 66.7 хувиар дэмжигдлээ. Дараагийн санал хураалт.

Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.4.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр батлагдсан менежментийн төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах, хянах, тайлагнах журам, аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”. Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ. Дараагийн санал.

Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийн "хамтран" гэсний дараа "төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа," гэж нэмэх. Санал хураалт.

Санал хураалтыг цуцалъя. Ганхүлэг гишүүн асуулт асууя.

**М.Ганхүлэг:** Энэ яг одоо ИНХ-аар шийдэж байгаа асуудлыг энэ нөлөөллийн бүсийн иргэд гэдгээр шийддэг болох асуудлыг яаж хагалах хэрэгтэй байгаад байна. Үнэхээр яг Байнгын хорооны гишүүд болон хуулийн төслийн ажлын хэсгийн гишүүд бүгд энийг дэмжээд байгаа юм уу? Тэр зам дагуу гээд тэгэхээр 5км дотор ганц ч айл байхгүй бол яах вэ? Эс үгүй бол ингээд 1 юм уу, 2-хон айл байвал яах вэ? Тэгээд наадах чинь ингээд ийм утгагүй ийм байдал руу л орох гээд байна л даа.

Тэгээд энэ 10.5 дээр байгаа энэ асуудал чинь хуучин бол ИНХ-аар энэ саналыг нь аваад ордог байсныг төсөлд хэрвээ хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа гэж нэмээд тэгээд энэ 10.5-аа үндсэндээ юу болгох гээд байна л даа

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нөлөөлөлд өртөх иргэдийн санал гэдэг ийм агуулга руу л орох гээд байна л даа. Тэгэхээр энэ хамгийн гол асуудлыг л юу байгаад байна л даа. Энийгээ хэдүүлээ яг сайн анзаарахгүйгээр дэмжээд явчих юм бол тухайн бүс нутагт иргэдийн саналыг нөлөөллийн бүс гэдэг нэрийдлээр цөөн тооны хүмүүсээс аваад ингээд уул уурхай болон томоохон ажлууд явах ийм байдал руу л орох гээд байна л даа.

Тэгэхээр нөлөөллийн бүсийг ингээд тайлбарлан асуухаар ингээд зарчмын дагуу мэргэжлийн хүмүүс тогтооно оо л гээд тэгж байна. Тэгээд тогтоохдоо харин тэр нь бол радиус тэр байгаа байдал юмаа харахаар чинь 1 айлын хоорондын зай ямар байгаа билээ? Тэгээд бид нар цөөхөн хэдхэн иргэдээс юмаа очиж танилцуулаад саналыг нь авсан болоод тэгээд энэ төслүүдээ хүчээр явуулахын хэрэг юу байгаа вэ? Асуудлаа буруу л оношлоод байх шиг санагдаад байх юм. Үндсэндээ үр өгөөжгүй байгаа асуудлаа бид нар ярьж тэр шийдлийг нь гаргах ёстой болохоос биш бол ингээд хүчлээд энэ төслүүдээ явуулаад байхаар чинь улам л иргэд, олон нийтийн эсэргүүцэл рүү бол орно шүү дээ. Тэгээд энэ дээрээ яг тийм шийдэл гаргахгүйгээр л бид нар шийдэх гээд байна даа.

**Б.Бейсен:** Ажлын хэсгийн ахлагч Уянга гишүүн хариулъя.

**Б.Уянга:** Төслүүд энэ зэрэглэл 1, 2, 3 гээд уншсан аягүй олон янзын төслүүд байгаа. Яг зүгээр газар дээр талбай эзлээд л оршиж байгаа үйл үйлдвэрийн асуудал ч байна. Бүхий л ер нь төвийн шугамд холбогдсон үйлчилгээний байгууллагууд бүгдээрээ яг энэ хуулиар бол үнэлгээгээ хийлгээд үйл ажиллагаагаа эхлүүлж байгаа.

Ерөнхий үнэлгээ хийгддэг ээ. Ерөнхий үнэлгээний үе шатын үеэр болохоороо сум болон дүүргийн Засаг дарга нараас мэдээллээ аваад албан бичгээр хариугаа аваад ингээд явдаг процесс. Бид нар болохоор багийн хурлыг, хорооны хурлыг огт байхгүй болгосон зүйл байхгүй. Энэ нь болохоор Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуулиараа зохион байгуулалтын ажил нь бол хэвээр үргэлжилж байгаа. Энэ нөлөөллийн үнэлгээг дагаад Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хуульд өөрчлөлт оруулна гэж дагаж орж ирээгүй. Тэгэхээр тэр хуульдаа хадгалагдаж байгаа харилцаа тэндээ хадгалагдаад хэвээрээ явна.

Ерөнхий үнэлгээний процессын үед Засаг даргад хамаг мэдээлэл танилцуулагдах үеэр яг энэ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу багийнхан багийн Засаг даргадаа мэдээлэл өгөх ёстой. Багийн Засаг дарга нь өөрсдөө ямар байдлаар иргэдээсээ мэдээлэл авах вэ, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуулийнхаа биелэлтийг хангаж ажиллах вэ гэдэг нь сонголтын асуудал болж үлдэж байгаа юм.

8.4.8 одоо хүчин төгөлдөр хууль дээр хүртэл багийн хурлын тогтоол гэсэн өгүүлбэр байхгүй шүү дээ. Багийн иргэдийн мэдээллийг, саналыг нь тусгана аа л гэсэн агуулга байгаа. Яг одоогийн байгаа найруулгаараа яг практик дээр хэрэгжихгүй байгаа учраас яг одоо найруулга нь нөлөөллийн бүсийн иргэд. Нөлөөллийн бүсийн иргэд нь тухайн багтаа амьдарч байгаа учраас багийн хурал байдаг. Энэ нь зохион байгуулах эрх нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуульдаа хадгалагдсан хэвээрээ байгаа.

**Б.Бейсен:** Ганхүлэг гишүүн тодруулъя.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**М.Ганхүлэг:** Нөлөөллийн бүс гэдэг маань тодорхойгүй байна. Хэчнээн айл яаж шийдэх вэ гэдэг нь тодорхойгүй байна. Энийг хийх гэж байгаа юм маань бас эргэлзээтэй байна.

Хоёрт нь 8 8.4.8 дээр бол ИНХ-ын санал тэмдэглэлийг яах вэ эцсийн шийдэл биш юм биш байна. Энд ингээд тэмдэглэл хэлбэрээрээ, санал хэлбэрээрээ бүрдүүлж байгаа материал дотор юманд нь ороод ингээд байгаль орчны ерөнхий нарийвчилсан үнэлгээгээ тусгаад явчихаар юу нь болохгүй байгаа юм бэ? Энэ нь үндсэндээ ИНХ-аараа ч ярихгүй зөвхөн Засаг дарга нь шийдээд, нэг бол нөлөөллийн бүсийн цөөхөн хэдхэн хүмүүс хийгээд явж байгаа ингээд хүч түрсэн ийм агуулга юм руу улам орохоор чинь бас болохгүй байна аа л гэдгийг л хэлээд байна л даа. Тэгээд энийг уул нь бол зарчмын зөрүүтэй санал гаргаад энэ Байнгын хороон дээрээ хагалчихмаар байна. Энэ байгаль орчноо хамгаалах Байнгын хороо юм уу, эс үгүй бол өөр Байнгын хороо юм уу би тэрийг одоо ойлгохгүй байна.

**Б.Бейсен:** Уянга гишүүн хариулъя.

**Б.Уянга:** Манай Байнгын хороо бол мэдээж мэргэжлийн Байнгын хороо. Яг нөлөөллийн үнэлгээний гол хуулиа ярилцаж байна.

Багийн хуралтай холбоотой тогтоол гаргахтай харилцааг ерөөсөө анхнаасаа одоо хүчин төгөлдөр байгаа хууль дээр ч хөндөөгүй Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хуулиараа зохицуулагдаад явж байгаа харилцаа байгаа. Тэгэхээр яг энэ багийн хурал зохион байгуулах эсэх нь болохоор тухайн багийнхан Засаг даргын эрх мэдлийн асуудал болно.

Ингээд зөвшөөрөл байдлаар тогтоол гаргуулаад явъя аа гэвэл Зөвшөөрлийн тухай хуулиа хөндөж оруулж ирэх ёстой байгаа. Тэгэхээр Зөвшөөрлийн тухай хууль дээр нэмэлт, өөрчлөлт санал болгоод оруулаад ирэх нь Улсын Их Хурлын гишүүд бид нарт бол нээлттэй асуудал аа.

**Б.Бейсен:** Санал хураалт.

Санал 66.7 хувиар дэмжигдлээ. Дараагийн санал хураалт.

Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу 14.1.2 дахь заалтын "орон нутгийн захиргаа" гэснийг "нутаг дэвсгэрийн захиргаа" гэж өөрчлөх. Санал хураалт.

Санал 66.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Сэддоржоос 2 санал ирүүлсэн байна. Саналыг уншиж танилцуулъя. Саналын томъёололд.

“Хуулийн төслийн 10.5-д байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланг төслийг хэрэгжүүлэгч үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулна.” гэснийг “байгаль орчинд нөлөөллийн үнэлгээний тайланг төслийг хэрэгжүүлэгч үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

иргэдэд танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулах бөгөөд төслийн улмаас иргэдэд учирсан хохирол, зардал, амьжиргааны алдагдал, усны хүртээмж, байгаль орчин, нийгэм, соёлын орчинд үзүүлсэн үр дагавар, нөлөөллийг хамааруулан иж бүрнээр үнэлж бүрэн нөхөн төлнө гэж найруулах саналтай гэсэн байх юм. Санал хураалт.

Санал 27.8 хувиар дэмжигдээгүй. Дараагийн саналын томьёолол.

Хуулийн төслийн 10.4-д “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 10.5-д заасан танилцуулгаас гарсан саналын нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан эсэх болон үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээч мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.” гэснийг “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 10.5-д заасан танилцуулгаас гарсан саналыг нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан эсэх болон үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээч мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэх бөгөөд хэрэв байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тухайн төсөл нь усны нөөц, амьжиргааны тогтвортой байдалд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх нь тогтоогдсон тохиолдолд төслийг хэрэгжүүлэхийг хориглоно.” гэж өөрчлөлт оруулах гэсэн байна. Санал хураалт.

Санал 11.1 хувиар дэмжигдээгүй.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Асуулт асуух гишүүд байхгүй байна. Санал ирээгүй байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрс өгнө үү?

Асуулт асуух гишүүд байхгүй байна. Ажлын хэсгээс санал ирээгүй байна.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрс өгнө үү?

Байхгүй байна. Ажлын хэсгээс санал ирээгүй байна.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрс өгнө үү?

Асуулт асуух гишүүд байхгүй байна. Ажлын хэсгээс 2 санал ирсэн байна.

Төслийн 7 дугаар зүйлийн хуулийг дагаж мөрдөх хугацааг “2026 оны 8 дугаар сарын 01” гэж өөрчлөх. Санал хураалт.

Санал 72.2 хувиар дэмжигдлээ.

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

10.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх, бүтэц найруулга, хууль зүйн техникийн засварыг хийх. Санал хураалт.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна. Дараагийн асуудалд оръё.

13.45 цаг

**Байнгын хорооны тогтоолын төсөл “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэх бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тухай.**

Тогтоолын төсөл та бүхэнд танилцуулъя. “Ажлын хэсэг байгуулах тухай”,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас тогтоох нь:

1.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Б.Уянга Монгол Улсын Их Хурлын гишүүн, гишүүд Алтаншагай Монгол Улсын Их Хурлын гишүүн, Б.Бейсен Монгол Улсын Их Хурлын гишүүн, Ж.Чинбүрэн Монгол Улсын Их Хурлын гишүүн, А.Ундраа Монгол Улсын Их Хурлын гишүүн.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулахыг ажлын хэсэг Б.Уянгад зөвшөөрсүгэй гэсэн.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу?

Ганхүлэг гишүүнээр тасалъя. Ганхүлэг гишүүн.

**М.Ганхүлэг:** Зүүн бүс Сүхбаатар аймагтай холбогдолтой асуудал байгаа учраас ажлын хэсэгт нь орж, боломжтой бол ороод ажиллая аа гэсэн саналтай байна. Тэрийг та, тийм ороод ажиллая гэсэн.

**Б.Бейсен:** Ганхүлэг гишүүнийг нэмээд оруулъя.

Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад бэлдье гишүүд. Санал хураалт.

Тогтоолын төсөл 83.3 хувиар дэмжигдлээ. Дараагийн асуудалд орёё.

13.47 цаг

**“Бусад” асуудал, Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцье.**

Байнгын хорооны даргад нэр дэвшигчийн танилцуулга Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Отгонбаяр танилцуулна.

**У.Отгонбаяр:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 26.7, 30 дугаар зүйлийн 30.1.6, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргад Бат-Өлзийн Бат-Эрдэнийн нэрийг дэвшүүлж байна.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ нь 1977 онд Улаанбаатар хотод төрсөн. Ам бүл 6. Эхнэр, 4 хүүхдийн хамт амьдардаг.

1995 онд нийслэлийн ерөнхий боловсролын 77 дугаар сургууль, 1999 онд Улаанбаатар их сургуулийг түүх судлаач, Солонгос хэлний орчуулагч, 2003 онд Бүгд Найрамдах Солонгос Улсын Топас академийг иргэний агаарын тээврийн мэргэжлээр, 2010 онд Улаанбаатар их сургуулийг түүхийн ухааны магистр, 2022 онд Отгонтэнгэр сургуулийг эрх зүйн бакалаврын зэрэг тус тус эзэмшсэн.

2003-2012 онд “Силк Роуд” ХК-ийн үүсгэн байгуулагч, ерөнхий захирал, 2015 онд Монгол Улсын Шадар сайдын зөвлөх, 2015-аас 16 онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд дарга, 2016-аас 17 онд Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, 2018-аас 19 онд Засгийн газрын дэд дарга бөгөөд “Эрдэнэс Монгол” ХК-ийн ТУЗ-ийн дарга, 2020-2022 онд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга, 2022-2024 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, 2024 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Улсын Их Хурал, Засгийн газарт ажилласан байдал, мэдлэг, чадвар, туршлагыг үндэслэн Бат-Өлзийн Бат-Эрдэнийг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байна.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

**Б.Бейсен:** Отгонбаяр даргад баярлалаа. Байнгын хорооны дарга нэр дэвшүүлэх талаар өөр саналтай гишүүд байна?

Лодойсамбуу гишүүн.

**Ч.Лодойсамбуу:** Байнгын хорооны гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

зүйлийн 1.5, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу Байнгын хорооны дарга солигдохтой холбоотой асуудлаар 5 хоногийн завсарлага хүсэж байна. Бейсен гишүүн бол манай намын бүлгийн ахмад туршлагатай, хашир туршлагатай парламентч. Тийм учраас манай бүлэг дээр Байнгын хороодыг хүлээлцэхтэй холбоотой ярилцаж шийдвэрлэх асуудлууд байна. 5 хоногийн завсарлага хүсэж байна дарга.

**Б.Бейсен:** Лодойсамбуу гишүүний гаргасан саналын дагуу 5 хоногийн завсарлага өгч байна.

Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул хурлаа завсарласныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

13.51 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Д.ОТГОНДЭЛГЭР*